

Мормоны Номын Төгс эзэмших сургаал: 2-р шалгалт

АЛМА - МОРОНАЙ

Төгс эзэмших сургаалын эшлэл

1–3-р асуултын хувьд, үг хэллэг тус бүрийн хажууд буй хоосон зайд холбогдох эшлэлийн үсгийг бич. Шалгалтын энэ хэсэгт судруудаа ашиглахгүй.

Түлхүүр үг хэллэг	Судрын эшлэл
_____ 1. “Энэрэл бол Христийн цэвэр хайр.”	a. Алма 39:9
_____ 2. “Мөн тэрээр бүх төрлийн өвчин мөн зүдгүүрүүд мөн уруу таталтуудыг тэвчих болно.”	b. Алма 41:10 c. Моронай 7:45–48 d. Хиламан 5:12
_____ 3. “Нүдээрээ шунасныхаа араас дахин бүү яваасай.”	e. Алма 7:11–13

Судрын түлхүүр үг хэллэг

4–6-р асуултын хувьд, төгс эзэмших сургаалын судрын түлхүүр үг хэллэгийн дутуу орхисон үгсийг нөхөж бич. Шалгалтын энэ хэсэгт судраа бүү ашигла.

4. “Христэд итгэлтэй байж, _____, үнэн _____ асуу. . . . Мөн Ариун Сүнсний хүчээр та нар бүх зүйлийн үнэнийг _____ болно.” (Моронай 10:4–5)
5. “Бидний _____ дээр . . . та нар _____ тавих ёстойг санагтун.” (Хиламан 5:12)
6. “_____ тань _____ дарааг хүртэл та нар _____ хүлээн авахгүй.” (Ифер 12:6)

Бодит амьдрал дээрх нөхцөл байдалд хэрэгжүүлэх

Та судруудаа шалгалтын үлдсэн хэсэгт ашиглаж болно.

7–9-р асуултын хувьд, дараах нөхцөл байдалд орсон хүнд туслах төгс эзэмших сургаалын судрын Алмагаас Моронай хүртэлх нэг юм уу хэд хэдэн хэсгийг тодорхойл. Та яагаад эдгээр судрыг сонгосноо тайлбарла.

7. Сүмийн талаар суралцаж буй залуу эмэгтэй Есүс Христийг дагахын тулд юу хийх ёстойгоо мэдэхийг хүсэв.

8. Таны найз Есүс Христийн ач холбогдлыг ойлгохгүй байгаа бөгөөд Тэр бидний төлөө юу хийснийг танаас асуув.

9. Нэгэн залуу эр Сатаны уруу таталтаас хамгаалагдахын тулд Бурханы тусламж, хүчийг хэрхэн хүлээн авч болохыг мэдэхийг хүсдэг.

Сүнслэг мэдлэг олж авах зарчмууд

10–11-р асуултын хувьд, сүнслэг мэдлэг олж авах зарчмуудыг ашиглах мэдлэг, чадвараа харуул.

10. Та дараах сүнслэг мэдлэг олж авах зарчмуудыг хэн нэгэнд хэрхэн тайлбарлах вэ?

a. Итгэлээр үйлд.

b. Утга санаа болон асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судал.

c. Тэнгэрээс томилогдсон эх сурвалжуудаар дамжуулан илүү гүн гүнзгий ойлголт олж авахыг эрэлхийл.

11. Нэгэн залуу эмэгтэй заримдаа Бурханы зарлигууд хэтэрхий их хязгаарлаж байна гэж мэдэрдэг. Тэрээр хамгийн сайн арга зам гэж өөрийн бодож байгаа замаар амьдарвал илүү аз жаргалтай байх болов уу гэж боддог.

Дараах асуултуудад хариул.

a. Тэрээр итгэлээр үйлдэхийн тулд юу хийж болох вэ?

b. Энэ нөхцөл байдлыг мөнхийн талаас харах нь түүнд хэрхэн тус болох вэ?

с. Төгс эзэмших сургаалын судрын хэсгүүд бол тэнгэрээс томилогдсон эх сурвалжуудын нэг жишээ юм. Энэ нөхцөл байдалд төгс эзэмших сургаалын судрын аль хэсэг тустай байж болох вэ? Хэрхэн туслах вэ?

12. Мормоны Номын хоёрдугаар хагаст судалсан төгс эзэмших сургаалын судрын 12 хэсгээс аль төгс эзэмших сургаалын судрын хэсэг танд онцгойлон тустай эсвэл утга учиртай байсан бэ? Яагаад?
